



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/31/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум
2020 он

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захирал
бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Ариунаа

Утас: 99092469 Цахим хаяг: ariunaach@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 90077079 Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК

Утас: 99108763 Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1. Аудитын гэрчилгээ


 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn	ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН ҮҮД СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Т.БАТТУЯА ТАНАА
2020.02.28 № 1-6/226 танай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын Үүд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Дорноговь аймгийн Замын Үүд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Т.Баттуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-аас 2020 оны 02 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захиалгаар “Уваа-уул аудит” ХХК-ийн захирал Ч.Мөнхтуяа, чанарын хяналтын менежер А.Оюун, аудитор Ц.Мөнхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 10 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймаг дахь Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь: “Чанартай боловсролд Монголын ирээдүй оршино.”

Бүрэн дунд боловсролын үйл ажиллагааны чиглэлийг “Бага, дунд боловсролын тухай хууль”-ийн 6 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар, гадаад хэлний зохих мэдлэг эзэмшүүлэх;
- Байгаль, нийгэм, хүмүүнлэг, математик, мэдээлэл зүйн шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх;
- Мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан амьдарч, хөдөлмөрлөх, үргэлжлүүлэн суралцахад бэлтгэх;
- Бие бялдраа хөгжүүлж, эрүүл аж төрөх ёсыг сахих, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

“Төрийн албаны тухай” шинэчилсэн хуулийг дагаж гарсан эрх зүйн актууд. Тухайлбал:

- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох,
- Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоол, Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох,
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол, Нөхөх төлбөр олгох,
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол, Төрийн албан хаагчид шагнал олгох, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн мөнгөн урамшуулал олгох,
- Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол, төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин урамшуулал олгох,
- Түрээсийн сурах бичиг ашиглуулах талаарх БСШУСС-ын 2019 оны А/302 дугаар тушаал
- Нийгмийн даатгалын тухай хуульд 2017 онд орсон өөрчлөлтийн дагуу шимтгэлийн хувь хэмжээний өөрчлөлт зэрэг болно.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous-3” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд эрсдэлтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 4 дүгээр улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.0 хувийг сонгов.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшин “дунд” гэж үзсэнтэй холбоотой юм.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 15,870.2 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үе шат болон нийт зардлын дүнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44,123.5 мянган төгрөгөөр буюу 0,9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	12,010.6	3962.4	-8,048.2
Урьдчилгаа	0.0		0.0
Бараа материал	50,733.7	76,197.0	25,463.3
Үндсэн хөрөнгө	4,609,195.0	4,635,903.4	26,708.4
Нийт хөрөнгө	4,671,939.3	4,716,062.8	44,123.5
Өр төлбөр	44.1	27.3	-16.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,671,895.2	4,716,035.5	44,140.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,671,939.3	4,716,062.8	44,123.5

Бараа материалын үлдэгдэл 25,463.3 мянган төгрөгөөр өссөн нь БСШУСЯ-наас ирүүлсэн ном, сурах бичиг 18,375.2 мянган төгрөг, Туркийн хамтын ажиллагааны нийгэмлэг ТИКА-аас хэрэгжүүлсэн эрүүл мэндийн кабинетын тохижуулах төслийн хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгө 4,508.5 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чийрэгжүүлэлтийн танхим тохижуулахад

4,086.5 мянган төгрөгийн хэрэглэгдэхүүн, ном авсан зэрэг нь бараа материалын үлдэгдэл өсөх шалтгаан болжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 16,708.4 мянган төгрөгөөр өсөхөд 2018 онд хийгдсэн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийхдээ газрын үнэлгээг 53,000.0 мянган төгрөгөөр дутуу үнэлж авсныг залруулж, газрын үнэлгээг нэмэгдүүлсэн, тайлант үеийн элэгдлийн зардлаар буурсан зэрэг нь голлон нөлөөлсөн байна. Энэхүү үнэлгээний зөрүү нь эздийн өмчийн дансны өөрчлөлтөд мөн нөлөөлсөн болно.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт зориулан 1,519,229.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,194,541.7 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс 324,687.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Гүйцэтгэлээр нийтдээ 1,413,551.1 мянган төгрөгийг зарцуулсан нь батлагдсан төсөвтэй харьцуулахад 105,678.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдаж, 93.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Ийнхүү төлөвлөсөн зардлыг дутуу зарцуулах болсон шалтгаан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын бүлгийн зардал 37,159.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 63,311.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсанаас шалтгаалжээ. Тухайлбал: байрны ашиглалттай холбоотой тогтмол зардлын төлөвлөгөөг өнгөрсөн жилийн төлөвлөгөөнөөс 84,451.7 мянган төгрөгөөр өсгөж баталсан бол цалингийн зардлыг жилийн дундуур 82,286.9 мянган төгрөгийн өөрчлөлт оруулж баталсан байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт төсвийн дансаар нийтдээ 9,360.0 мянган төгрөгийн орлогыг заалны түрээсийн орлого, сурах бичгийн түрээсийн орлого зэргээс хүлээн авч, 6,350.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 3010.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн, буцааж авахаар авлага үүсгэсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 горимыг хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 78,858.0 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс, 78,858.0 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 1 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Аудитын явцад дараах 78,858.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залрууллаа.
Үүнд:

1. 2018 онд хийгдсэн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээгээр төсөвт байгууллагын газрыг үнэлж орлогод авсан ба тус сургуулийн газрын үнэлгээг хийхдээ тооцооллын алдаа гаргаж 53,000.0 мянган төгрөгөөр газрыг дутуу үнэлж, нягтлан бодох бүртгэлд тусгасан байсныг залруулж, зөв дүнгээр бүртгэлд тусгуулав.
2. Төсвийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг төрийн сангийн хуулганаас зөрүүлсэн, төсвийн тохируулга хийгээгүйгээс гарсан 18,200.0 мянган төгрөгийн алдааг залруулж, төрийн сангийн хуулгатай тохируулсан.

3. Тайлант жилд газарт элэгдэл байгуулсан байсан 7,233.3 мянган төгрөгийн элэгдлийг залруулав.
4. Санхүүгийн тайлангийн уялдааг томъёоллоор шалгахад 424.7 мянган төгрөгийн зөрүү үүссэнийг залруулсан.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төсвийн төлөвлөлт үндэслэлтэй хийгдэж, батлагдаж байгаа эсэх, төсвийн жилийн дундуур өөрчлөлт оруулах үндэслэлд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ. Учир нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлуудыг төлөөд, өргүй гарсан байхад материаллаг хэмжээний зарцуулагдаагүй төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл үлдэж байгаа нь анхаарал татаж байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 134 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар 11,802.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тавьсныг барагдуулсан байна. Худалдан авах ажиллагааг хууль, журамд нийцүүлэх талаарх зөвлөмжийг хэрэгжүүлж байна. Зөвлөмжийн биелэлт 100%

Тус сургуулиас аудитын зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 12 сарын 24-ний өдрийн 02/41 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тооцсон 15,870.2 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийг зөрчиж элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 22 нэр төрлийн 22,097.4 мянган төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгө ашиглагдаж байна.

3.1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд толилуулсан хөрөнгийн үнэ цэнэ буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд буруу мэдээлэл өгөх үр дагавартай.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	62,744,266.24	80,159,396.13
33	АВЛАГА	12,010,613.44	3,962,417.44
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,583,452.44	306,117.44
335	Бусад авлага	8,427,161.00	3,656,300.00
3351	Байгууллагаас авах авлага	8,427,161.00	3,656,300.00
35	БАРАА МАТЕРИАЛ	50,733,652.80	76,196,978.69
351	Түүхий эд материал	52,905.00	8,250.00
35130	Эм боох материал	52,905.00	8,250.00
354	Хангамжийн материал	50,680,747.80	76,188,728.69
35410	Бичиг хэргийн материал	977,380.00	18,771,067.61
35420	Аж ахуйн материал	49,235,365.80	57,411,897.08
35440	Түлш, шатах тослох материал	400,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	68,002.00	5,764.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,609,195,019.47	4,635,903,379.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,609,195,019.47	4,635,903,379.03
392	Биет хөрөнгө	4,392,018,561.26	4,365,726,920.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,019,233,970.00	4,019,233,970.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(787,500.00)	(37,054,452.54)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	317,060,459.86	333,932,119.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	(121,284,900.29)	(153,147,050.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	232,102,398.40	267,572,533.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(77,969,066.55)	(89,910,436.26)
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,600,000.00	18,600,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,040,000.16)	(3,836,666.82)
39217	Ном	6,103,200.00	10,336,904.00
393	Биет бус хөрөнгө	217,176,458.21	270,176,458.21
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(593,541.79)	(593,541.79)
39303	Бусад биет бус хөрөнгө	217,000,000.00	270,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,671,939,285.71	4,716,062,775.16
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	44,092.06	27,300.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	44,092.06	27,300.00
413	Өглөг	44,092.06	27,300.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	17,792.06	00.00
4136	Бусад өглөг	26,300.00	27,300.00
41361	Байгууллагад төлөх өглөг	24,500.00	25,500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,800.00	1,800.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,671,895,193.65	4,716,035,475.16
51	Засгийн газрын хувь оролцоо	4,671,895,193.65	4,716,035,475.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	217,000,000.00	270,000,000.00
51101	Өмч: - төрийн	217,000,000.00	270,000,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,386,191,140.69	3,377,331,422.20
51210	Өмнөх үеийн үр дүн	3,386,191,140.69	3,386,191,140.69
51220	Тайлант үеийн үр дүн	-	(8,859,718.49)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,068,704,052.96	1,068,704,052.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,671,939,285.71	4,716,062,775.16

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,820,085,303.32	1,575,146,233.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	625,471,503.32	46,556,633.41
120	Нийтлэг татварын бус орлого	625,471,503.32	46,556,633.41
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	625,471,503.32	46,556,633.41
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,403,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	618,068,503.32	46,556,633.41
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,194,613,800.00	334,047,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,191,613,800.00	1,194,541,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,194,613,800.00	1,194,541,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,000,000.00	9,360,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	350,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	9,010,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	324,687,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	324,687,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,295,625,723.08	1,584,005,951.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,295,625,723.08	1,584,005,951.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,208,970,623.08	1,419,192,453.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	728,682,999.50	937,486,878.81
210101	Үндсэн цалин	532,665,661.50	657,703,696.99
210102	Нэмэгдэл	111,456,902.00	187,637,769.00
210104	Урамшуулал	84,560,436.00	92,145,412.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,170,771.12	109,904,587.75
210201	Тэтгэврийн даатгал	54,363,026.72	77,776,028.44
210202	Тэтгэмжийн даатгал	11,587,571.02	5,756,362.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,280,087.29	7,133,135.10
210204	Ажилгүйдлийн даатгал	1,973,978.21	1,418,202.82
210205	Эрүүл мэндийн даатгал	13,966,107.88	17,820,858.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	233,529,039.00	262,867,957.67
210301	Гэрэл, цахилгаан	13,467,055.00	15,619,362.00
210302	Түлш, халаалт	206,880,478.80	246,624,745.67
210303	Цэвэр, бохир ус	13,181,505.20	623,850.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,872,771.37	8,335,079.50
210401	Бичиг хэрэг	1,298,940.00	1,078,680.00
210402	Тээвэр, шатахуун	360,000.00	1,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,100,000.00	893,671.00
210404	Ном, хэвлэл	234,000.00	102,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	894,000.00	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,985,831.37	2,160,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	523,000.00
210408	Бараа материал акалсны зардал	00.00	2,127,028.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,507,200.00	3,507,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,500,000.00	-
210604	Урсгал засвар	2,007,200.00	3,507,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	4,392,000.00

210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	4,392,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	798,000.00	1,499,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	798,000.00	1,499,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,909,842.09	91,199,049.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	367,500.00	785,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,097,660.00	7,546,910.02
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	124,444,682.09	82,867,139.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,655,100.00	164,813,498.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	85,625,000.00	59,135,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,450,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	56,153,000.00	55,944,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,472,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,740,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	63,311,203.33
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	63,311,203.33
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,030,100.00	42,367,295.38
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,030,100.00	42,367,295.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	524,459,580.24	(8,859,718.49)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	524,459,580.24	(8,859,718.49)

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,202,016,800.00	1,528,589,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,194,613,800.00	1,528,589,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,191,613,800.00	1,194,541,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,191,613,800.00	1,194,541,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,403,000.00	9,360,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	350,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,403,000.00	9,010,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	324,687,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	324,687,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,174,546,800.00	1,499,920,738.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,174,546,800.00	1,499,920,738.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,083,812,500.00	1,335,819,639.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	719,093,057.00	938,262,119.81
210101	Үндсэн цалин	472,744,629.00	666,469,212.99
210102	Нэмэгдэл	172,610,692.00	180,072,253.00
210104	Урамшуулал	73,737,736.00	91,720,653.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,060,163.00	107,069,803.81
210201	Тэтгэврийн даатгал	54,039,976.00	77,750,448.81
210202	Тэтгэмжийн даатгал	6,755,110.00	5,630,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,404,047.00	7,036,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,351,111.00	1,407,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,509,919.00	15,244,755.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	238,527,500.00	257,869,496.67
210301	Гэрэл, цахилгаан	13,467,055.00	15,619,362.00
210302	Түлш, халаалт	211,878,939.80	241,626,284.67
210303	Цэвэр, бохир ус	13,181,505.20	623,850.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,883,000.00	5,988,481.00
210401	Бичиг хэрэг	1,300,000.00	800,000.00
210402	Тээвэр, шатахуун	700,000.00	800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,100,000.00	893,671.00
210404	Ном, хэвлэл	955,000.00	494,810.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	750,000.00	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,078,000.00	2,750,000.00
2105	Нормативт зардал	2,725,000.00	1,799,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,725,000.00	1,799,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,887,200.00	3,507,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,880,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,007,200.00	3,507,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	4,392,000.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	4,392,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,184,180.00	1,499,700.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,184,180.00	1,499,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,952,400.00	15,430,938.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,441,500.00	1,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,510,900.00	14,330,938.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,734,300.00	164,101,098.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	89,704,200.00	55,412,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,402,200.00	54,612,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,472,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	830,000.00	800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,030,100.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,030,100.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	66,321,203.33
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	66,321,203.33
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	42,367,295.38
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	42,367,295.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>27,470,000.00</u>	<u>28,668,862.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>27,470,000.00</u>	<u>28,668,862.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>27,470,000.00</u>	<u>28,668,862.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	27,470,000.00	28,668,862.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,470,000.00	28,668,862.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(27,470,000.00)</u>	<u>(28,668,862.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,861,731,560.45	2,861,731,560.45
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,861,731,560.45	2,861,731,560.45
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	217,000,000.00	00.00	524,459,580.24	741,459,580.24
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	217,000,000.00	1,068,704,052.96	3,386,191,140.69	4,671,895,193.65
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	217,000,000.00	1,068,704,052.96	3,386,191,140.69	4,671,895,193.65
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	53,000,000.00	-	-	53,000,000.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(8,859,718.49)	(8,859,718.49)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	270,000,000.00	1,068,704,052.96	3,377,331,422.20	4,716,035,475.16

4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,519,229,600.00	1,413,551,101.29	105,678,498.71	93.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,519,229,600.00	1,413,551,101.29	105,678,498.71	93.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,459,278,600.00	1,358,138,501.29	101,140,098.71	93.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	975,421,900.00	938,262,119.81	37,159,780.19	96.1
210101	Үндсэн цалин	674,550,200.00	666,469,212.99	8,080,987.01	98.8
210102	Нэмэгдэл	189,421,700.00	180,072,253.00	9,349,447.00	95.0
210104	Урамшуулал	111,450,000.00	91,720,653.82	19,729,346.18	82.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,718,800.00	107,069,803.81	648,996.19	99.4
210201	Тэтгэврийн даатгал	71,113,300.00	77,750,448.81	-6,637,148.81	109.3
210202	Тэтгэмжийн даатгал	7,321,200.00	5,630,100.00	1,691,100.00	76.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,151,400.00	7,036,900.00	2,114,500.00	76.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,830,300.00	1,407,600.00	422,700.00	76.9
210205	Эрүүл мэндийн даатгал	18,302,600.00	15,244,755.00	3,057,845.00	83.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	321,180,700.00	257,869,496.67	63,311,203.33	80.2
210301	Гэрэл, цахилгаан	25,500,000.00	15,619,362.00	9,880,638.00	61.2
210302	Түлш, халаалт	277,880,700.00	241,626,284.67	36,254,415.33	86.9
210303	Цэвэр, бохир ус	17,800,000.00	623,850.00	17,176,150.00	03.5
2104	Хангамж, бараа материалын зардал	6,000,000.00	5,988,481.00	11,519.00	99.8
210401	Бичиг хэрэг	800,000.00	800,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	800,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	893,671.00	6,329.00	99.3
210404	Ном, хэвлэл	500,000.00	494,810.00	5,190.00	98.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	250,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,750,000.00	2,750,000.00	-	100.0
2105	Нормативт зардал	1,800,000.00	1,799,900.00	100.00	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.00	1,799,900.00	100.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,507,200.00	18,507,000.00	200.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	5,999,800.00	200.00	100.0
210602	Тавилга	9,000,000.00	9,000,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	3,507,200.00	3,507,200.00	00.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	4,400,000.00	4,392,000.00	8,000.00	99.8

210702	Дотоод албан томилолт	4,400,000.00	4,392,000.00	8,000.00	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500,000.00	1,499,700.00	300.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00	1,499,700.00	300.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22750000.00	22750000.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	750,000.00	750,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,000,000.00	22,000,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59951000.00	55412600.00	4538400.00	92.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	59951000.00	55412600.00	4538400.00	92.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,151,000.00	54,612,600.00	4,538,400.00	92.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,519,229,600.00	1,413,551,101.29	105,678,498.71	93.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,194,541,700.00	1,152,174,404.62	42,367,295.38	96.4
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,194,541,700.00	1,152,174,404.62	42,367,295.38	96.4
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	324,687,900.00	261,376,696.67	63,311,203.33	80.5
132001	Орон нутгийн төсвөөс	324,687,900.00	261,376,696.67	63,311,203.33	80.5
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	84	84	-	-
620001	Удирдах ажилтан	1	1	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	57	57	-	-
620003	Үйлчлэх ажилтан	26	26	-	-

4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,360,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,360,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6350000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	350,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,010,000.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3,010,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9360000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,360,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	350,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,010,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020-02-25	Аудитын нэр: 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДГА-2020/31/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн “0” үлдэгдэлтэй үндсэн хөрөнгүүд ашиглагдаж байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Т.Баттуяа Б.Наранцэцэг